



СОЁМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№103 /103/

2021.08.02

ҮЙЛ ЯВДАЛ

МОНГОЛ УЛС, КАТАР УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР САНАЛ СОЛИЛЦЛОО



ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг Катар-Монголын Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хорооны дарга, хурандаа Набел Сороур, тус хорооны дарга асан бригадын генерал Мохаммед Хассан Ал Тавади нарыг өнгөрсөн Баасан гарагт хүлээн авч уулзлаа.

Уулзалтад БХЯ-ны ГХАГ-ын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлагч, бригадын генерал Б.Баатар, Цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, хурандаа Н.Нямжаргал, АУГ-ын газрын ЭДА-ны хэлтсийн дарга, хурандаа Т.Буянбат нар байлцав.

Уулзалтын үеэр ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг хэлсэн үгэндээ бригадын генерал Мохаммед Хассан Ал Тавади Катар-Монголын Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хорооны даргаар ажилласан хугацаандаа олон ажлыг хийж гүйцэтгэснийг нь онцоллоо. Тодруулбал, Катар Улсын ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Ганим Бин Шахин Ал-Ганим, Ахмед Бин Мохаммедийн цэргийн коллежийн захирал, хошууч генерал Фахад Мубарак Аль-Хаярин нарын /2018 он/, Тусгай хүчний командлалын штабын дарга, хурандаа Мохаммед Нажза Алхабаби тэргүүтэй төлөөлөгчдийн /2019 он/ манай улсад хийсэн албан ёсны айлчлалыг амжилттай зохион байгуулсан. Эдгээр айлчлалын үр дүнд Катар Улсад явагдаж буй тусгай хүчний сургалтад Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид оролцож байгааг дурдав.


Мөн манай улсад зохион байгуулагддаг "Хааны эрэлд" олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургалт, дадлагад Катар Улсын Зэвсэгт хүчний 2-3 цэргийн алба хаагчийг 2008 оноос хойш жил бүр тогтмол оролцуулж байсан төдийгүй "Хааны эрэлд-2018" олон улсын энхийг дэмжих ажиллагааны сургалт, дадлагад салааны бүрэлдэхүүнээр оролцсон, тэрхүү түүхэн цаг үетэй давхцан Катар Улсын ЗХЖШ-ын дарга албан ёсны айлчлал хийснийг онцолсон юм.

Тэрчлэн уг уулзалтын үеэр цар тахлын нөхцөл байдал нь бидэнд олон сорилтыг бий болгож байгаа ч хоёр улсын Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний хамтын ажиллагааг тасралтгүй хөгжүүлэх олон арга, хэлбэр байгаагийн дотор цахим орчин, техник, технологийн дэвшил чухал болохыг тодотголоо.

Уулзалтын төгсгөлд Монгол Улс болон Катар Улсын Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний цэргийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үйлсэд бригадын генерал Мохаммед Хассан Ал Тавадигийн оруулсан хувь нэмрийг өндрөөр үнэлж, Монгол Улсын Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медалиар шагнасныг нь гардуулж, баяр хүргэсэн юм. Мөн Катар-Монголын Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хорооны дарга, хурандаа Набел Сороурын ажилд амжилт хүссэний зэрэгцээ хоёр улсын Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцов. Сонирхуулахад, Монгол Улс Катар Улстай анх 1998 оны нэгдүгээр сарын 21-ний өдөр албан ёсны дипломат харилцаа тогтоосон бөгөөд хоёр орны ЗХЖШ-ын дарга нар "Монгол Улсын Зэвсэгт хүчин, Катар Улсын Зэвсэгт хүчин хоорондын хамтын ажиллагааны гэрээ"-нд 2007 онд Катар Улсад гарын үсэг зурснаас хойш 14 жилийн хугацаанд тасралтгүй хамтран ажиллаж байгаа юм.

Хурандаа Б.ОТГОНБАЯР

МЭНДЧИЛГЭЭ



Энэ жил Хятадын Ардын Чөлөөлөх Арми байгуулагдсаны 94 жилийн ойн баяр тохиож байна. Миний бие БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны нэрийн өмнөөс Хятадын Ардын Чөлөөлөх Арми байгуулагдсан ойн халуун баярын мэнд хүргэе!

94 жилийн туршид Хятадын Ардын Чөлөөлөх Арми Хятадын Коммунист намын удирдлага дор, золиосол гаргахаас буцахгүй, үндэсний тусгаар тогтнол, ард түмнийг чөлөөлөх болон Шинэ Хятад улсыг үүсгэн байгуулахад агуу их хувь нэмэр оруулсан билээ. Улс орны бүрэн эрхт байдлыг хамгаалах, аюулгүй байдал болон хөгжлийн эрх ашгийн төлөө чухал хувь нэмэр оруулсан юм.

Шинэ эрин үед орж, Ши Жиньпин даргын арми хүчирхэгжүүлэх үзэл санааны удирдлага дор, Хятадын Ардын Чөлөөлөх Арми тууштай улс төрд суурилан арми байгуулах, арми шинэчлэх, техник технологиор хүчирхэгжүүлэх, хуулийн дагуу арми удирдан зохион байгуулж дэлхийн тэргүүлэх арми болгох зорилтын дагуу урагшилж байна. "Хоёр зуун жил"-ийн зорилт болон Хятад үндэстний агуу их сэргэлт, Хятадын мөрөөдлийг биелүүлэхийн тулд тууштай баталгаагаар хангаж байна.

Хятадын арми шинэ эрин үед олон улсын цэргийн хамтын ажиллагааг иж бүрэн ахиулж, НҮБ-ын

энхийг сахиулах, терроризм, далайн дээрмийн эсрэг үйл ажиллагаа, шинэ төрлийн коронавирус цар тахлын эсрэг тэмцэх болон хүмүүнлэгийн тусламж зэрэг олон улсын өмнө хүлээсэн үүргээ идэвхтэй биелүүлж ирсэн. Дэлхийн энх тайван, тогтвортой байдал болон шударга ёсыг хамгаалахад тууштай хүч байсаар ирсэн.

Хятад, Монголын цэргийн харилцаа нь хоёр орны харилцааны чухал хэсэг юм. Сүүлийн жилүүдэд хоёр улсын цэргийн харилцаа тогтвортой хөгжиж, бүхий л салбарт хамтын ажиллагаа бодитоор тасралтгүй гүнзгийрч ирсэн нь бүх талаар хоёр орны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэв. Ялангуяа шинэ төрлийн коронавирусын дэгдэлт эхэлснээс хойш хоёр улсын арми харилцан бие биеэ дэмжиж, цар тахлын эсрэг хамтран тэмцэж байгаа нь найрсаг нөхөрлөлийг илтгэн харуулж байна.

Өдрөөс өдөрт төвөгтэй болж буй олон улс болон бүс нутгийн нөхцөл байдалд Хятад, Монгол хоёр улсын армиуд улам бүр хамтын ажиллагаагаа бэхжүүлж, хоорондын ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлж, найрсаг харилцаагаа тасралтгүй гүнзгийрүүлж дэлхийн энх тайван, шударга ёсыг хамгаалахад хамтран идэвхтэй үүрэг гүйцэтгэхийн тулд илүү их амжилтад хүрч чадна гэдэгт итгэж байна.

БНХАУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙД ЦАЙ ВЭНЬРУЙ

ЦАХИМ ЦУГЛАРАЛТ БОЛЛОО

Хуурай замын цэргийн командлалаас нэгтгэл, ангиудын цэргийг агаарын довтолгооноос хамгаалахын дарга, тагнуулын офицеруудын цахим цугларалтыг зохион байгууллаа. Эл цахим цугларалт "Хуурай замын цэргийн ЦАДХ-ын анги, салбарын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага" сэдвийн хүрээнд Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудын ЦАДХ-ын офицеруудын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгыг агуулсан юм.

Цугларалтын арга хэмжээг нээж Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, хошууч генерал Б.Амгаланбаатар хэлсэн үгэндээ "Та бүхэнд Монгол Улсад орчин цагийн

Зэвсэгт үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн баярын мэндийг хүргэе. Эрхэм зенитчид та бүгд орчин үед явагдаж байгаа зэвсэгт мөргөлдөөн, түүнд ашиглаж байгаа агаарын довтолгооны хэрэгслийг байнга судалж, анхаарлынхаа төвд байлгадаг гэдэгт итгэлтэй байна. Орчин үед дэлхийн улс орнууд Зэвсэгт хүчнийхээ ЦАДХ-ын зэвсэглэлд ихээхэн анхаарч, шинэ зэвсэглэлийг туршин нэвтрүүлж, өдөр, сар, жилээр техник технологийн хөгжлийг ашиглан хурдацтай хөгжүүлж байгааг та бүхэн анзаарч буй биз ээ. Зэвсэгт хүчин болоод Хуурай замын цэрэг өнгөрсөн хугацаанд зүгээр суусангүй.

(Үргэлжлэл нь арын нүүрт)

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 18	☁️ 9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 28	☁️ 21

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 33	☁️ 19

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.849.0	2.851.0
EUR 🇪🇺	3.38.0	3.390.0
CNY 🇨🇳	441.0	442.0
RUB 🇷🇺	38.20	39.40
JPY 🇯🇵	25.70	26.24
KRW 🇰🇷	2.43	2.52

ЗУРХАЙ

2021.08.02 ДАВАА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 24/

ЗУНЫ АДАГ ХӨХӨГЧИН ХОНЬ САРЫН НЭГ ЦАГААН ХАРЬ МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ

Наран ургах, шингэх:

05:30-20:27

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Төрөн түгэхүй

Суудал:

Мод

Тухайн өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, морь, хонь, тахай, нохой, гахай үхэр, луу, могой, хонь, болой.

Эл өдөр андаг тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нээнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 165.147 +992	ЭДГЭРСЭН 143.803 +2058	НАС БАРСАН 820 +5
----------------------------------	---------------------------	----------------------

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 4123 +74	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 248 +64	ЭДГЭРСЭН 3798 +64
-----------------------------	--------------------------------	----------------------

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 198,973,312
Эдгэрсэн Нийт: 179,595,844
Нас барсан Нийт: 4,239,692

ДЕЛЬТА ХУВИЛБАР АНХЛАРАХ ШИНЭ ШИНЖ ТЭМДЭГ

Суулгах, Хамар битүүрх, нус гоожих, Булчин өвдөх, Урт хугацаагаар толгой өвдөх, Бөөлжих, Хөсөөл өвдөх, Бие тавиурх, идэх.

ДЭЭРХ ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ ШИНЖИЛГЭЭ ӨГӨӨРӨЙ.

СПОРТ



Хүн төрөлхтний баяр цэнгэл ТОКИО-2020 Олимпын XXXII наадам энэ сарын 23-нд эхлээд байна. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний нэрийн өмнөөс тус наадамд спортын 7 төрлөөр 12 тамирчин эрх аван оролцож байна.

Тус наадамд Монгол Улс оролцож эхэлснээс хойш Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны тамирчид тасралтгүй оролцсон байдаг бөгөөд Олимпын наадмын мөнгө, хүрэл, шагналт байрыг нийт 13 тамирчин хүртсэн байна. Зэвсэгт хүчний төлөөлөл нийт тамирчин дайчиддаа амжилтын дээдийг хүсэн ерөөе.

МУГТ М.АНХЦЭЦЭГ ӨНӨӨДӨР ХҮЧ СОРИНО

МУГТ М.Анхцэцэг өнөөдөр хүч сорино. Хүндийг өргөлтийн төрөлд эх орноо төлөөлөн Токиогийн олимпыг зорьсон МУГТ М.Анхцэцэг өнөөдөр Эмэгтэйчүүдийн 87 кг-ын жинд хүчээ сорих юм. Хүндийг өргөлтийн эмэгтэйчүүдийн хуваарь манай цагаар 15:30-д явагдах төлөвтэй байна. Мөн түүнээс гадна манай гурван тамирчин өрсөлдөнө.

07:30 - Буудлагын эрэгтэйчүүдийн 25 метрийн хурдан гар бууны хоёрдугаар дасгалд Э.Даваахүү цэц сорино. Тус төрөлд нийт 27 тамирчин оролцож байгаагаас манай тамирчин эхний өдрийн байдлаар 23-т жагсаж байна. 10:50-Хүндийн өргөлтийн



эмэгтэйчүүдийн +87 кг жинд Э.Билэгсайхан өрсөлдөнө. Тэрээр эхний шатанд Францын Кумба Ларроктой барилдана. 10:58-Чөлөөт бөхийн эмэгтэйчүүдийн -68 кг жинд

ЦАХИМ ЦУГЛАРАЛТ БОЛЛОО

(Түрүүч нь эхний нүүрт)



Тухайлбал, Зэвсэгт хүчний 120, 167, 327 дугаар ангиудын байлдааны зэвсэглэл техникийн боломжийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр ажиллаж, тодорхой үр дүнд хүрээд байна.

Та бүгд одоо байгаа зэвсэглэлээ сэргээн сайжруулах талаар анхаарч идэвхтэй ажиллах шаардлагатай. Энэ удаагийн цугларалт ч уг асуудлаар хариулт өгөх байх гэж найдаж байна” хэмээсэн юм.

Цугларалтыг ХЗЦ-ийн ЦАДХ-ын дарга, хурандаа Б.Эрдэнэпил, ЦАДХ-ын офицер, хошууч Х.Шийрэв нар удирдаж, нэгтгэл, ангиудын ЦАДХ-ын дарга, тагнуулын офицер, албад салбарын захирагч нар оролцлоо.

АГААРЫН ЦЭРГИЙН АЛДАР ХҮНДИЙГ ТИВ, ДЭЛХИЙН ТАВЦАНД ЦУУРАЙТУУЛАХААР АРЛЫН ОРНЫГ ЗОРИНО



Үндэсний шигшээ багийн тамирчин, олон улсын хэмжээний мастер, Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн алба хаагч, ахлах ахлагч Ц.Бямбажав “Токио-2020” зуны олимпын 32 дугаар наадамд марафон гүйлтийн төрлөөр эх орноо төлөөлөн оролцох эрхээ авч, цэрэг хүний тэсвэр хатуужил, бие бялдрын өндөр бэлтгэлжилт, хурд хүчийг харуулж, Монгол Улсынхаа нэрийг тив, дэлхийн тавцанд

цуурайтуулахаар бэлтгэл сургуулилтаа базааж байгаа ба энэ сарын 4-ний өдөр Япон Улсыг зорьж, 8-ны өдрийн өглөөний 06.00 цагт гараанд гарах юм. Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, хошууч генерал О.Энхбаяр өнгөрсөн сарын 28-ны өдөр ахлах ахлагч Ц.Бямбажавтай цахимаар холбогдон зуны олимпын наадамд оролцох болсонд нь баяр хүргэж, амжилт хүссэнээс гадна

Агаарын цэргийн нийт хамт олны сэтгэлийн дэмжлэг, мэндчилгээг уламжиллаа.

Энэ үеэр хошууч генерал О.Энхбаяр “Зөвхөн Агаарын цэргийн бие бүрэлдэхүүн гэлтгүй Зэвсэгт хүчин, улс орон даяараа тамирчид та бүхнээр бахархаж байна. Олимпод түрүүлэх, медаль авах нь хэдий сайхан ч, эрхээ хангаад оролцоно гэдэг тамирчин хүнд асар их нэр хүнд байдгийг санаж, сэтгэл санаагаар өөдрөг байж, тэмцээндээ бүх анхаарлаа төвлөрүүлээрэй. Марафоны төрөл нь нүсэр их тэсвэр, тэвчээр, хатуужил шаарддагийг бид мэднэ. Цэргийн алба бол тэсвэр, тэвчээрийн илэрхийлэл байдаг. Ийм аугаа спортод Агаарын цэргийн алба хаагч, ахлагчийн бүрэлдэхүүний төлөөлөл болсон таныг эх орныхоо нэрийн өмнөөс тэр дундаа Зэвсэгт хүчнийхээ нэрийг дуудуулан оролцох гэж байгаад бид бүхэн бахархаж байна” гэлээ.

ЦАХИМ ШУУДАНД

ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГ ШАЛГАЛТЫН БЭЛТГЭЛ АЖЛЫН ХҮРЭЭНД...

Зэвсэгт хүчний 336 дугаар анги

Тус ангийн ахлагч, тэргүүн ахлагч Б.Батхшиг, ажиллагааны ахлагч сургагч ахлагч С.Гантулга тэргүүтэй ангийн ахлагчийн нийт бие бүрэлдэхүүнийг хамруулсан бүтээлч ажлыг өрнүүлэв.

Тус ажлын хүрээнд хорооны жагсаалын талбайн индрийг бүрэн засварлаж, биеийн тамир спортын гаднах талбайн өнгө үзэмжийг сайжруулж, зориулалтын дагуу дахин төхөөрөмжиллөө. Энэхүү бүтээлч ажил нь ахлагчийн алба нэг хүсэл зорилгод чиглэн ажиллаж, бие бүрэлдэхүүнийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтад оруулан эмх



журамтай, сахилга баттай, хэрхэн чанартай хийж, цаг гар нийлэмжтэй ажиллаж, хугацаанд нь гүйцэтгэдгийг өгсөн үүрэг даалгаврыг илтгэж байгаа юм.

“БУЯНТ-УХАА”-Д МОТОРЫН ДУУ ҮРГЭЛЖИЛСЭЭР...



Хөшигийн хөндийн олон улсын нисэх онгоцны буудал ашиглалтад орсонтой холбоотойгоор Буянт-Ухаа нисэх буудлыг цаашид хэрхэн ашиглах, хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг олон нийтэд хүртээмжтэй хэлбэрээр танилцуулах өдөрлөг өнгөрсөн Баасан гарагт зохион байгуулагдлаа. Тус өдөрлөгт Зэвсэгт хүчний Агаарын цэргийн бие бүрэлдэхүүн оролцсон юм.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Олон улсын нисэх буудлуудын нэрийг өөрчлөх, тэдгээрийн ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолд тус олон улсын нисэх буудлыг цаашид олон улс, орон нутгийн нислэгийн нөөц нисэх буудал,

ерөнхий зориулалт, нисэхийн сургалт, захиалгат, онцгой, тусгай үүргийн нислэг, агаарын хөлгийн засвар, үйлчилгээ болон онцгой байдал, иргэний нисэхийн бусад үйл ажиллагаанд ашиглахаар заасан байдаг.

Анхлан зохион байгуулагдсан энэхүү өдөрлөгөөр Буянт-Ухаа нисэх буудлыг цаашид олон улсын нисэхийн сургалт, дадлагын төв болгон ашиглах, ингэснээр олон улсын сургалтын байгууллагуудтай өрсөлдөхүйц хэмжээнд хүргэж, нисэхийн мэргэжлийн сургалтыг өөрийн оронд нутагшуулах талаар зорьж байгаа юм. Ингэснээр нисэхийн мэргэжилд дурлаж, сонирхож байгаа залуус Монголдоо хямд зардлаар

нарийн мэргэжил эзэмших боломж бүрдэх аж.

Өдөрлөгийн үеэр Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалаас сөнөөгч онгоц, нисдэг тэрэг, нисгэгчгүй нисэгч төхөөрөмжийн талаар иргэдэд танилцуулсан юм. Түүнчлэн нисэх зурваст нисгэгчдийн ур чадварыг харуулсан бага оврын агаарын хөлгүүдийн үзүүлбэрүүд болон Зэвсэгт хүчний 303, 337 дугаар ангийн цэргийн нисгэгчид ОБЕГ-ын харьяа Үндэсний аврах бригадын шүхэрчидтэй хамтран үзүүлэх тоглолт хийсэн нь иргэдийн анхаарлыг ихэд татаж байлаа. Ийнхүү “Буянт-Ухаа”-д моторын дуу үргэлжилсээр байгаа гэдгийг эл арга хэмжээ харууллаа. Тус өдөрлөгт ирсэн зочдын дийлэнх нь залуус байсан нь тэдний нисэхийн салбарт хандуулж байгаа анхаарал, сонирхлыг илтгэн харуулж байгаа юм. Ташрамд дурдахад Монгол Улсад нисэх хүчин байгуулагдсан түүх нь Монгол Ардын хувьсгалт цэргийн агаарын хүчнээс Зэвсэгт хүчний нисэх хүчин, Цэргийн тээврийн отрядас Монголын иргэний агаарын тээвэрт хүрсэн түүхтэй. Ийнхүү цэргийн нисэх хүчин нь иргэний агаарын тээврийн суурь болж түүний бие даасан статустай болоход чухал үүрэг гүйцэтгэсэн билээ.

ИХ ГОВИЙН ГАРИНЗОНЫ 7 ДУГААР САРЫН ТЭРГҮҮНҮҮД ТОДОРЛОО



Байлдааны гавьяаны Улаан тугийн одонт, жанжин Д.Сүхбаатарын

нэрэмжит Зэвсэгт хүчний 336 дугаар ангийнхан 7 дугаар сарын тайлангаа

хэлэлцэж, ажил үйлсээрээ бусдыгаа манлайлсан сарын тэргүүнүүдээ тодруулан, шилжин явах дарцаг гардууллаа. Сарын “Тэргүүний хамт олон”-оор зангилгааны дарга, дэслэгч А.Амарсайхан даргатай холбооны алба, “Тэргүүний салбар”-аар ахмад С.Түмэндалай даргатай тийрэлтэд артиллерийн батарей, “Тэргүүний ахлагч”-аар ахлагч Ө.Цэрэн, “Тэргүүний ажилтан албан хаагч”-аар Ю.Уламбаяр, “Тэргүүний хугацаат цэргийн алба хаагч”-аар байлдагч Д.Борхүү нар тус тус шалгарсан юм.

Дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ